

Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд
ногоон бонд гаргах тухай

Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 76 дугаар зүйлийн 76.1.6, "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.13.31 дэх заалт, "Төрийн банк" ХК-ийн Гүйцэтгэх захирлаас 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн "Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд ногоон бонд гаргах саналыг шийдвэрлүүлэх тухай" 01/5830 дугаар албан тоотыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр танилцуулсан "Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд ногоон бонд гаргах саналыг шийдвэрлүүлэх тухай" саналыг хэлэлцэн дэмжиж, Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд 10.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн дүнтэй ногоон бондыг дараах нөхцөлийн дагуу гаргахаар шийдвэрлэсүгэй.

Бондын арилжаа	Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд
Бондын төрөл	Энгийн хүүтэй ногоон бонд
Бондын нийт нэрлэсэн дүн	10.0 тэрбум төгрөг
Нэгж бондын нэрлэсэн дүн	100,000 төгрөг
Бондын нийт тоо, ширхэг	100,000 ширхэг
Бондын хугацаа	12 сар
Бондын жилийн хүү	16%
Хүү төлөгдөх давтамж	Улирал тутам
Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах бонд эзэмшигчийн эрх	Банк хоёрдогч зах зээлээс 91 дэх өдрөөс эхлэн буцаан дуудах эрх үүснэ.
Бондын барьцаа	Татан төвлөрүүлсэн дүнгийн 100-150%-тай тэнцэх МИК актив ТЗК үнэт цаас
Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт	Монгол улсын "Ногоон таксономи", "Төрийн банк" ХК-ийн Тогтвортой санхүүжилтийн хүрээнд тодорхойлсон 12 чиглэлийн шаардлага хангасан төсөл хөтөлбөр санхүүжүүлнэ.
Бондын хадгалалт, төлбөр тооцоо	"Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХК

2. Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд ногоон бонд гаргахад хамтран ажиллах андеррайтерыг сонгож, хамтран ажиллах гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Б.Болор-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН